

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД АНХААРАХ АСУУДАЛ

*Цагдаагийн сургуулийн
Цагдаагийн эрх зүйн тэнхимийн багш,
цагдаагийн дэслэгч Д.Цэрэнлхам*

Товч агуулга: Аливаа нийгмийн зохион байгуулалт гэр бүлээр эхэлдэг төдийгүй гэр бүл нь төр улс бүрэлдэх үндэс болдог. Нийгмийн суурь нэгж болох гэр бүлийн гишүүний жам ёсны эрхийг зөрчиж байгаа хамгийн түгээмэл хэлбэр нь хүчирхийлэл бөгөөд түүний дотор ураг төрлийн холбоотой хүмүүсийн хооронд үйлдэгддэг “*ахуйн хүрээний*” гэх тодотголтой гэр бүлийн хүчирхийлэл нь дэлхий дахины өмнө тулгамдаж буй асуудлуудыг тэргүүлж, тархцаараа гэр бүлд төдийгүй нийгэмд мэдэгдэхүйц хор уршгийг дагуулах болов.

Тиймээс дэлхий нийтэд “Гэр бүл нь нийгэм, төрөөр хамгаалуулах эрхтэй”¹ хэмээн тунхагладаг нь эцсийн бүлэгт нийгмийн тогтвортой байдлыг хангах явдал бөгөөд гэр бүлийн харилцааны хэвийн байдлыг хангах, хамгаалах нь төрийн бодлогын хамгийн чухал асуудлуудын нэгэнд зүй ёсоор тооцогддог.²

Гэр бүлийн хүчирхийлэл нь зөвхөн тухайн гэр бүлийн дотоод асуудал бус, нийгэм бүхэлдээ тогтворгүйтэх эрсдэлийг дагуулах, гэр бүлийн гишүүдийн эрхийг ноцтой зөрчдөг “гэмт хэрэг” хэмээн дэлхийн 125 оронд хуульчилсан төдийгүй НҮБ-аас Гэр бүл дэх хүчирхийлэлтэй тэмцэх тухай загвар хууль боловсруулан гаргасан байдаг.

Манай улсын хувьд ХХ зууны сүүл үеэс иргэний нийгмийн байгууллагуудын хүчин чармайлтаар “Гэр бүл дэх хүчирхийлэл нь хүний эрхийг зөрдөг “гэмт хэрэг”, нийгмийн тулгамдсан асуудал” болохыг төр засаг, албан тушаалтан, ард иргэдэд нээн харуулсан нь саяхан болтол “Гэр бүлийн дотоод асуудал буюу зөрчил” гэж үздэг байсан бүх нийтийн үзэл хандлагыг өөрчилж чадсан төдийгүй Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг батлуулж чадсан юм.

2015 оны шинэчлэн батласан Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлгийн 11.7 дугаар зүйлд “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэргийг хуульчилж өгсөнтэй холбоотойгоор тус гэмт хэргийн талаар авч хэлэлцэх нь олонтаа болсон юм. Учир нь гэр бүлийн хүчирхийлэл нь далд явагдахын зэрэгцээ, давтагдан даамжирдаг бөгөөд шинж чанарын хувьд улам ноцтой болдог өвөрмөц шинж бүхий гэмт хэрэг юм. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь газар зүйн байршил, соёл, шашин шүтлэг, нийгэм, эдийн засгийн байдлаас үл хамааран бүхий л хүрээг хамарсан дэлхий нийтийн тулгамдсан асуудал бөгөөд хүний эрхийн хамгийн түгээмэл зөрчлүүдийн нэг юм.

Иймд судлаач миний бие энэхүү сэдвийн хүрээнд урьдчилан сэргийлэх чиглэлээр манай цагдаагийн байгууллага хэрхэн ажилладаг талаарх бяцхан судалгааг хийлээ.

Түлхүүр үг: Гэр бүл, гэр бүлийн хүчирхийлэл, урьдчилан сэргийлэлт, мэргэжил, мэргэшил.

¹Хүний эрхийн түгээмэл тунхаглал. 1946. 16 дугаар зүйл. х.3

²Д.Зүмбэрэлхам. Монгол Улсын Гэр бүлийн хууль, түүний хэрэгжилт номын өмнөх үг. УБ., 2009. х.6

Үндсэн хэсэг. Хүчирхийллээс хүчирхийлэл үүсдэг. Монголчууд үр хүүхдээ үлгэрлэн дуурайлуулж өсгөдөг байсан. Эцэг, эх л зөв байвал хүүхэд хэзээ ч муу хүн болно гэж байхгүй. Гэр бүлийн хүмүүжил ирээдүйд бие даасан, төлөвшилтэй, соёлтой бие хүн болон төлөвших эх үүсвэр юм.

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн эрх ашиг зөрчигдөж, хуулиар хамгаалагдаж чадахгүй байна. Яагаад гэвэл эдийн засгийн хараат байдал, амьжиргааны түвшин доогуур зэргээс хамаарч үйлчилгээ авахад төлдөг төлбөрийг төлж чадахгүй байна. Тухайлбал: хохирогч өөрт шаардлагатай хуулийн үйлчилгээ авах тутамдаа төлбөр, хураамж, торгууль, улсын тэмдэгтийн хураамж, баривчлах байрны төлбөр, эрүүлжүүлэх төлбөр, шүүх эмнэлгийн үзлэг, эвлэрүүлэн зуучлагчийн хөлс, шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх ажиллагааны зардал, төлбөртэй өрөө гэх мэтчилэн зүйлсд 400000 төгрөг зарцуулах шаардлагатай болдог. Мөн хууль хяналтын байгууллага нь захиргаадах шинжтэй байдаг учираас айж эмээх эрх зүйн мэдлэг дутах мөн цаг хугацааны хувьд чирэгдэл ихтэй байх нь манай улсын хууль хангалттай асуудлыг шийдвэрлэхээр хэмжээний байдаггүйтэй холбоотой байгаа юм.

Хохирогч нь ихэнхдээ сэтгэл зүй нь хувьд дарамттай, хямралд өртсөн, бие даан шийдвэр гаргаж чадахгүй, байнгын айдастай байдаг нь өөрийгөө хамгаалж хууль хяналтын байгууллагад хандан туслалцаа авах, мэргэжлийн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлдэг байгууллагад мэдэгдэн зөвлөгөө авах, мөн хороо, сумынхаа нийгмийн ажилтан, эмчтэйгээ нягт уялдаа холбоотой ажилдаггүйн улмаас гэмт хэрэг нь нуугдмал далд хэлбэртэй үйлдэгдээд байгаа. Тиймээс тэднийг эрүүл нийгэмд, хайрлан, хамгаалж, зөвлөн тусалж, дэмжиж тусалсанаар бид хүчирхийлэлд өртөж буй хохирогчдыг хүчирхийллээс хамгаалж тэдний эрх ашгийг хамгаалж чадна.

Ийм л нийгмийг бүтээж хүчирхийлэлгүй Монголыг бий болгохын төлөө хичээж судлан, шалтгаан нөхцлийн тогтоож, арга замыг олж, хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгоход судлаачид, хуулийн байгууллагынхан, нийгмийн ажилтан, эмч нар болон хөрш айлын хүн бүрийн оролцоо чухал юм.

Манай Улс гэр бүлийн хүчирхийллийн талаар нилээд олон арга хэмжээ авч Төрийн болон төрийн бус байгууллагууд үйл ажиллагаа явуулдаг. Тухайлбал: Хүчирхийлэлийн эсрэг үндэсний төв, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дэргэдэх Хүүхдийн тусламжийн утас, мөн Хөөрхөн зүрх” ТББ “Гэр бүлийн хүчирхийлэл ба Covid19 - podcast” хөтлөн явуулсаар байна.

Монгол Улсад энэ төрлийн гэмт хэргийн тоо сүүлийн жилүүдэд өссөн хандлагатай байх ба мөрдөн шалгах ажиллагааны хувьд цагдаагийн байгууллага гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээллийн ихэнх хувийг гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй үндэслэлээр татгалзаж хааж байгаа нь дахин үйлдэгдэх, даамжрах нөхцөл байдлыг үүсгэж байна. Үүнтэй холбоотойгоор гэмт хэрэг, зөрчлийн нотлох баримт устаж үгүй болох хохирогч мэдүүлгээсээ буцаж ятгалгад өртөх цаашлаад даамжирч хохирогчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учрах аюул тулгарч байдаг. Нөгөөтэйгүүр хохирогч мэдээллээсээ буцах, худал мэдүүлэг өгөх зэрэг нь хохирогчийг дарамтлах, цагдаагийн байгууллагад мэдээллэсэнтэй холбогдуулан дарамтлах, амь насыг заналхийлэх, айлгаж сүрдүүлэх зэрэг асуудал гарснаар энэ төрлийн гэмт хэргийн анхдагч бөгөөд амьд нотлох баримт болох хохирогч дахин цагдаагийн байгууллагад хандахаас айх зэрэг асуудал нилээдгүй гарсанаар олон хүүхэд, эмэгтэйчүүд энэ гэмт хэргийн хохирогч болон үлдэж байгаа дүр зураг харагдаж байна.

Дараагийн нэг асуудал бол гэр бүлийн хүчирхийллийн гэрч, хохирогчийг хамгаалах асуудал байна. 2020 оны эхний хагас жилийн байдлаар нийслэлийн хэмжээнд 129 гэмт хэрэг бүртгэгдсэн байх бөгөөд 918 хүн гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн улмаас хохирч үлдсэн байна.³ Тэгвэл Монгол улсын хэмжээнд өнөөдрийн байдлаар гэр бүл хүчирхийлэлд өртсөн хохирогчийн амь нас,


³ ЦЕГ-ийн статистик мэдээлэл

эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах 14 түр хамгаалах байр, 18 нэг цэгийн үйлчилгээний төв үйл ажиллагаа явуулж байна. 2020 оны эхний хагас жилийн байдлаар түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвүүдээр 486 хохирогчид үйлчилгээ үзүүлж ажилласнаар 51 эмэгтэйчүүд, 435 хүүхдийн аюулгүй байдлыг ханган ажилласан судалгаа байдаг байна.⁴

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т “Тухайн орон нутгийн хүн амын тоо, эрүүгийн болон нийгмийн хэв журмын нөхцөл байдлыг харгалзан цагдаагийн байгууллагын бүтцэд цагдаагийн мэргэшсэн алба хаагчдаас бүрдсэн нэгжтэй байж болно” гэж заасны дагуу гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажлын үр дүнг сайжруулж, бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/301 дүгээр тушаалаар “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” хэлтсийг байгуулжээ.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хэлтэс нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Тус хэлтэс нь:



Дээрх бүрэлдэхүүнээс гадна 21 аймаг болон нийслэл, сум дундын цагдаагийн хэлтсүүдэд тус бүр нэг, нэг албан хаагч Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ахлах мэргэжилтэн гэсэн нэршилтэйгээр батлагдсан орон тоонд ажиллаж байна.

Мөн 21 аймаг, нийслэлийн 9 дүүрэгт 680 хамтарсан баг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг явуулж байна.

Цагдаагийн байгууллагаас гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиг үүрэг:

1. Цагдаагийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлд цагдаагийн алба хаагч гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох гэж заагаад таслан зогсоох ажиллагааг;
2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 25 дугаар зүйлд цагдаагийн байгууллага, алба хаагчийн үүргийг; /Энэ зүйлийн онцлог заалт нь хүчирхийлэл үйлдэгч, хохирогчийн талаарх бүртгэл хөтлөх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, ашиглах; гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдээллийг хүлээн авч, шаардлагатай тусламж, зөвлөгөө өгөх, холбон зуучлах утас 24 цагаар ажиллуулах, тухайн орон нутгийн хүн амын тоо, эрүүгийн болон нийгмийн хэв журмын нөхцөл байдлыг харгалзан цагдаагийн байгууллагын бүтцэд цагдаагийн мэргэшсэн


⁴ Гэр бүл хүүхэд залуучуудын газраас гаргасан статистик мэдээлэл

алба хаагчдаас бүрдсэн нэгжтэй байж болно гэж заасан. Бусад заалт нь Цагдаагийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлд заасан чиг үүрэгтэй давхцаж байна/

3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйл цагдаагийн байгууллагын хүлээх нийтлэг үүргийг тус тус зааж өгсөн байдаг.

Дээрх заалтуудаас харахад Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр доторхой заалт байхгүй, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэл, чиг үүргийг ерөнхийд нь тусгаж өгсөн байна.


Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх, алба хаагчдын мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд зохион байгуулсан сургалт.



Дээрх судалгаанаас үзвэл албан хаагчдыг мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтууд хангалттай зохион байгуулагдаж буй нь харагдаж байна. Мөн эдгээр албан хаагчидтай ярилцлага хийхэд гэр бүлийн хүчирхийллийн талаарх тэдний ойлголт, хандлага өөрчлөгдөж, нэмэгдэж байгааг хэлж байна.

Энэ чиглэлээр ажиллаж байгаа албан хаагчдыг мэргэшүүлэх болон чадавхжуулах сургалтуудыг шат дараатай зохион байгуулж буйгаас гадна Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн эчнээ болон 1+1 мэргэшүүлэх хөтөлбөрийн ангийн сонсогч, суралцагч нарт **“Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа”** нэршилтэй 2кр хичээлийг 1 улирлын турш зохион байгуулж байна. Ингэхдээ урьдчилан сэргийлэх бүлэг сэдвийн хүрээнд ердөө лекц, семинар, дасгалын хичээлийг тус бүр 2, 2 цаг буюу нийт 6 цагийн хичээл, сургалтыг зохион байгуулж байна.

Гэр бүлийн хүчирхийлэл, түүний хор уршгийн талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлж, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч болон хүчирхийлэлд өртөгчийн зан төлөвийг өөрчлөх, хүчирхийллийг үл тэвчих нийгмийн хандлагыг төлөвшүүлэх, нуугдмал гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, хохирогчийн эрх, хууль ёсны ашиг, сонирхолыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд дэмжлэг үзүүлэхэд төрийн болон төрийн бус байгуулага, иргэдийг оролцоог нэмэгдүүлэх зорилгоор соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.





Дээрх урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээнүүдийг жилд 1 удаа 22-28 хоногийн хугацаатай улсын хэмжээнд зохион байгуулсан байна.

Ингэхдээ тараах, хэвлэмэл материал/баннер, санамж, наалт, стикер зэрэг/-ыг 213.304 ширхэгийг хэвлэн тараасан байна.

Хүснэгт 3.2.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан:

2019 он					
Д/д	Төрөл	Тоо	Үзсэн хүний тоо	Хуваалцсан тоо	Таалагдсан байдал
1	Урьдчилан сэргийлэх видео контент	25	3.157.999	46.808	27.154
2	Нөлөөллийн видео контент	12	697.211	9300	2349
3	Зорилтот мэдээ, мэдээлэл	10	284.654	3012	978
4	Зурган постер	16	779.122	5316	1676
5	Блог хөтлөгч	8	213.707	1415	1116
Нийт		71	4.848.039	59.199	32.655
2020 он					
д/д	Төрөл	Тоо	Үзсэн хүний тоо	Хуваалцсан тоо	Таалагдсан байдал
1	Зорилтот видео контент	6	1.024.329	41.883	4.573
2	Нөлөөллийн видео контент	20	1.511.405	10.798	5.459
3	Зорилтот мэдээ, мэдээлэл	35	200.290	7.981	905
4	Зурган постер	51	990.651	75.497	6.294
Нийт		112	3.726.675	136.159	17.231

Цагдаагийн албаны тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиудад гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрхэн ажиллах тодорхой заалт байхгүй.

Гэхдээ гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын чиглэлийг дараах байдлаар зааж өгсөн.

- Ерөнхий
- Тусгай
- Нэг бүрчилсэн
- Соён гэгээрүүлэх
- Гэмт хэрэг зөрчлийг хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх.

Гэвч практик дээр эдгээр чиглэлийн хүрээнд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээ төдийлөн хангалттай сайн явагдахгүй байна.

Тухайлбал, 2018-2020 онд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор соён гэгээрүүлэх чиглэлээр 3 удаагийн аяныг 22-28 хоногийн хугацаатай /1 жилд 1 удаа/ зохион байгуулсан байна. Аяны хүрээнд зохион байгуулсан ажил, арга хэмжээний тоон судалгааг харахад хангалттай олон харагдаж байгаа боловч нөгөө талаасаа эдгээр нь ялангуяа нэгжүүд дээр төлөвлөгөөний биелэлтийг хангах зорилгоор нэр төдий явагддаг нь харагдаж байна. Үүний шалтгаан нь дүүрэг болон орон нутгийн цагдаагийн байгууллагын нэгжүүд дээр гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тусгайлсан орон тоо, мэргэшсэн алба хаагч хангалтгүй, цагдаагийн алба хаагчийн ажлын ачаалал их зэрэг байгаа нь орон нутгийн ажилтнуудтай хийсэн ярилцлага, уулзалтаас ажиглагдаж байв.


Мөн дээр дурдсанчилан цагдаагийн хэлтэс бүрт гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ахлах мэргэжилтэн байгаа хэдий ч эдгээр нь ЦЕГ-ын даргын 2020 оны “Эрх олгох тухай” тушаалд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтнуудыг зааж өгсөн. Уг тушаалд гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ахлах мэргэжилтэн орсон нь урьдчилан сэргийлэх ажлыг явуулах үндсэн чиг үүрэг нь алдагдаж зөрчил шалгаж байгаа нь бас нэг шалтгаан болж байна.

Цагдаагийн ерөнхий газар болон гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хамтран урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил, арга хэмжээнүүдийг жил бүр зохион байгуулж байгаа бөгөөд эдгээр ажиллагаанд бусад байгууллага, иргэдийг татан оролцуулж байгаа нь сайшаалтай.

Энэ ажлыг цаашид улам сайжруулахын тулд дараах асуудалд анхаарал хандуулах нь зүйтэй. Үүнд:

- Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэргэжилтний тоог нэмэгдүүлэх;
- Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтнуудын жагсаалтаас гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэргэжилтэнг хасах; /зөрчил шалгах биш зөвхөн урьдчилан сэргийлэх үндсэн чиг үүргээ хэрэгжүүлдэг байх/
- Цагдаагийн сургуулийн цагдаагийн ажил-эрх зүй хөтөлбөрийн 4 жилийн ангид “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа” хичээлийг оруулах, цаг сэдвийн төлөвлөгөөнд тусгагдсан урьдчилан сэргийлэх бүлгийн цагийг нэмэгдүүлэх;
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиг үүрэг бүхий албан хаагчдыг сэтгэл судлалын чиглэлээр мэргэшүүлэх сургалтуудад хамруулах;
- Улсын хэмжээнд л урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулдаг бус нэгжийн хэмжээнд санал, санаачлагатай ажиллуулах идэвхжүүлэх арга хэмжээнүүдийг авдаг, зохион байгуулдаг байх.
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хамтарсан багийн уялдаа, хамтын ажиллагааг сайжруулах /энэ чиглэлээр сургалтууд сайн явагддаг боловч бодит байдал дээр биелэлээ олдоггүй, шалтгааныг нь санхүүжилт болон ажлын ачаалал гэж тайлбарладаг/
- Шинээр гэр бүл батлуулж байгаа хосуудыг гэр бүлээ батлуулахаас өмнө ч юм уу гэр бүлийн боловсролын чиглэлээр сургалтад хамруулдаг байх. /сум, дүүргийн нийгмийн ажилтан/
- Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид л анхаараад байдаг бус хүчирхийлэл үйлдэгч болон үйлдэж болзошгүй /субъектийн судалгаанаас/ этгээдэд чиглэсэн соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээг илүү зохион байгуулдаг байх.

- ### График 3.2.



Энэ гэмт хэргийн гэрч, хохирогч нь эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг хангах гол үүрэг гүйцэтгэдэг субъектүүд боловч практик судалгаанаас үзэхэд тэдний аюулгүй байдлын хамгаалалт хангалтгүй байсаар байна. Гэрч, хохирогчийг сүрдүүлэх, дарамтлах, хуурч мэхлэх, мөнгө өгөх, гуйх, ятгах, заналхийлэх зэрэг хэлбэрээр нөлөөлөх явдал гарсаар байгаа бөгөөд үүний үр дагавар нь мэдүүлэг өгөхгүй байх, эсхүл худал мэдүүлэг өгөх, сэтгэлзүйн хувьд хэвийн байдлаа алдах, амиа хорлох оролдлого хийх зэрэг үйлдэлд хүргэж буйг судлаачид тэмдэглэсэн байна.⁵

Иймд Монгол улсын хувьд ялангуяа гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэрч, хохирогчийн эрүүл мэнд, аюулгүй байдлаа хамгаалуулах эрхийг баталгаатай хангах зорилгоор сэжигтэн, яллагдагчийг даруй баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авснаар болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх ач холбогдолтой байна.

⁵ Хохирогчийн эрхийн судалгааны төв, UNDP, “Гэрч, хохирогчийг хамгаалах үндэсний тогтолцоог бий болгох асуудал” судалгааны тайлан, 2010 он

Энэхүү судалгааны ажлын хүрээнд гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан нөхцлийг аливаа зүйлээс эрж хайх биш гэр бүл төлөвлөлт болон гэр бүлийн харилцаа, хүүхдийн хүмүүжлийн асуудал дээр тулгуурлан ажиллах нь зүйтэй юм.

Гэр бүл дэх хүүхдийн хүмүүжлийг зөв олгосноор хүчирхийллийн хэрэг өнөө маргаашдаа бус хойч үед үгүй болох давуу талтай гэж бодож байна. **Иймээс өнөөгийн практикт тулгамдаж буй асуудлын хүрээнд дараах саналыг гаргалаа.**

1. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийг үнэн зөвөөр шуурхай шалган шийдвэрлэж, хуульд заасны дагуу хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн даруй нотлох баримтуудыг түргэн шуурхай цуглуулж, гэмт хэрэг үйлдсэн, үйлдэхээр завдаж буй этгээдийг заавал баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авдаг байх, энэ гэмт хэрэгт өртсөн хохирогч, гэрч мэдүүлэг өгөхөөс татгалзах, гаргасан гомдлоо буцаан авсан эсэхийг үл харгалзан шүүхээр хэргийг шийдвэрлэхээс гадна хүчирхийлэгч этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг гарцаагүй болохыг олон нийтэд ойлгуулах нь нийтийн эрх, ашиг сонирхлыг хамгаалахад чухал ач холбогдолтой. Мөн цагдаагийн байгууллагаас хохирогч иргэний аюулгүй байдлыг хангах тал дээр сайтар анхаарч ажиллах гэмт хэрэгт өртсөн хохирогч нараас бодитой судалгаа авч, аюулын зэргийн үнэлгээг үнэн зөвөөр гарган авч тэдэнд зайлшгүй шаардлагатай хамгаалалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

2. Гэр бүлийн харилцаа, хүүхдийн хүмүүжлийн талаар гэр бүлийн гишүүн бүрийг хамруулсан үр дүнтэй яриа таниулга хийх энэ талын мэдлэг, мэдээллийг олон нийтэд таниулах ажил хийх, сургуулийн орчинд сэтгэл зүйч ажилуулах болон энэ талын мэдлэгийг олгох хүүхдийн хүмүүжлийн талаар хичээл оруулах. Хүүхдийн хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилтөд сөрөг нөлөө үзүүлэхүйц тоглоом, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгаа, цахим сүлжээнээс хүүхдийг хамгаалах талаар зөвлөмж, сэрэмжлүүлгийг холбогдох байгууллагуудтай хамтран бэлтгэж, олон нийтэд мэдээлэх. Ингэснээр гэр бүл дэх хүүхдийн хүмүүжлийн асуудлыг дэмжих нэг бодлого болох ба гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн тоо буурч, хохирогч нарын аюулгүй байдал хангагдаж тэдгээрийг учирч болзошгүй аюулаас хамгаалж урьдчилан сэргийлж чадах ба хүн ардыг хүчирхийллийн эсрэг тэмцдэг болгох юм. Гэр бүлийн асуудлыг тусгайлан хариуцдаг төрийн тогтолцоог бий болгох нь гэр бүлд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх салбар дундын зохицуулалтыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой болно.

3. Нийгэм даяар тогтсон жендерийн тэгш бус байдлыг халах, нийгэм, хүн амын сэтгэл зүйд жендерийн ялгаа гаргах асуудлыг засан залруулах. Энэ талын мэдээ мэдээллийг олон нийтэд түгээж сурталчилан таниулах олон талын судалгааны бодит үр дүнг танилцуулж бодитой арга хэмжээ авах нь жендерийн тэгш байдлыг хангах зорилтыг биелүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ.